



## ҮНДЭСНИЙ БИЧГИЙН ЗААХ АРГЫН ТУХАЙ АСУУДАЛД

<sup>a</sup>С.Гандэлгэр

<sup>a</sup>МУБИС-Багшийн сургууль, багш, магистр

Холбоо барих зохиогч: gandelger.s@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

### Хураангуй

Үндэсний бичиг нь залгамал бүтцэт хэлнийхээ онцлогт тохирсон хэлний зүйтэй, зөв бичих тогтсон ёстой, заан сургаж ирсэн тодорхой дэгтэй тул нийтээр даган мөрдөхөд маргаан багатай бичиг мөн. Эрдэмтдийн үзэж буйгаар өнгөрсөн түүхийн хугацаанд хэл бичиг заан сургалтыг

1. 1921 оноос өмнөх үе буюу гэрийн болон ордны сургалт бүхий үе, 1921-1940 он буюу гэрийн ба танхимын сургалт бүхий үе, 1941-1990 он буюу танхимын сургалтын үе, 1990 оноос эдүгээг хүртэлх буюу танхимын сургалтын /онлайн/ үе гэж 4 үед хуваасан байдаг. Тухайлбал, Үндэсний бичгийн сургалт дагнаж байсан түүрүү үеүдэд хэл бичгийн сургалт цагаан үсэг, үг таниулах төдийгөөр бичиг үсэгт тайлагдахад чиглэж байжээ. Энэ нь ч тухайн цаг үедээ үүргээ гүйцэтгэсээр ирсэн. Харин орчин цагийн сургалтад арга зүй болоод технологийн шинэчлэл хийгдэж буй тул Үндэсний бичиг заан сургалтын хувьд энэ цаг үетэй зохируулах шаардлага тулгарч байна.

Иймд өөрийн хэрэгжүүлж буй “Монгол бичиг” сонгон хөтөлбөрийн агуулгад шинэчлэл хийх, сайжруулах зорилгоор Б.Ренчиний “Монгол хэл” шүлгийн хүрээнд боловсруулсан арга зүйг танилцуулахыг зорилоо.

### Түлхүүр үг

Сургалт, судалгаа, хөтөлбөр, уламжлал, шинэчлэл

### Удиртгал

Бидний үед уламжлагдан ирсэн хэл зүйн бичиг, цагаан толгойнууд зорилго адил боловчиг цаг хугацаа, агуулга, арга зүй, бүтэц, зохиомжийн хувьд өөр өөрийн онцлогтой. Нөгөө талаас эдгээр нь нийлж, нэг нэгнээ нөхөж, харилцан эсрэгцэж, нэгэн иж, нэгдмэл цул болж буйгаараа онцлог юм. Тухайлбал, Онходын Жамьян “Монгол үсгийн аймаг, анхан сурах хөвгүүдийн оюуны амыг нээх тодорхой толь” (1914), “Монгол үсгийн ёсныг өчүүхэн төдий товчлон гаргасан байдал” (1921-1922), “Монгол үсгийн цагаан толгой оршив” (1922), “Анх сурах хөвгүүд охидыг удирдан сургах хичээлийн бичиг” (1925), “Урт өдрийн улиг үгний бичиг”

(1925), “Монгол үсгийн цагаан толгой оршив” (1926), “Монгол үсэг сурах бага хөвгүүдийн сурлагыг удирдах мөрийн бичиг хэмээх цагаан толгой оршив” (1927), “Анхан сурах хөвгүүдийн оюуныг нээх тодорхой толь хэмээх оршвой” (1927), “Монгол үсэгт сургах цагаан толгой хэмээх дэвтэр” (1928), Б.Дугаржав “Улаан толгой” (1919), Б.Ишдорж “Монгол үсэг” (1923), Намсрай гүн “Монгол үсгийн цагаан толгой” (1925), С.Шагж “Монгол бичгийг хялбар сурах дөт зам” (1934), Чой Лувсанжав нар “Монгол бичиг” (1986), Л.Дамдинжав “Цагаан толгой” (1990), Б.Осор нар “Монгол бичиг” (1991), Д.Баттогтох нар “Монгол бичиг” (1996), Ш.Чоймаа нар “Монгол бичиг-1” (2006), Г.Батсүрэн нар “Монгол бичиг-1” (2006), А.Цог-Очир нар “Монгол бичиг-1” (2006) зэрэг номын агуулга, үсэг заах дэс дараалал, сургах арга зарчим, бүтэц нь өөр өөрийн онцлогтой хэдий ч ерөнхий зарчим адилаар байна. Тодруулбал, Эгшиг үсгээ таниулсны сүүлчээр гийгүүлэгч үсэгтэй амь өгч, задгай үе, битүү үе уншуулаад, дараа нь богино үетэй үг, холбоо хоршоо үг, өгүүлбэр уншуулж, бичүүлж сургадаг байна. Эдгээрээс Ц.Дугаржавын “Улаан толгой” /бүтэн үгийн аргыг чухалчилсан/, Б.Ишдорж “Монгол бичиг” /эхээс үг, үгээс үе авч цагаан толгойг таниулдаг байсан/ сурах бичгүүд бусдаасаа онцлогтой.

Цагаан толгойн үсгийг заах ерөнхий зарчим нь энгийнээс нарийн, хялбараас хүнд рүү шилжихэд шүтэж, үсгийн махбодын адил шинж, үг бүтээхэд оролцох бүтээмжид тулгуурлан,

- Эгшиг үсэг
- Ацаг шүдэт үсэг
- Нумт үсэг
- Шилбэт үсэг
- Эвэрт үсэг
- Завжит үсэг
- Галиг үсэг гэсэн дарааллыг баримталж иржээ.

Уламжлалт заан сургалтыг орчин үетэй хослуулан сургалт, судалгаа явуулж буй авч, харь хэлний нөлөө, цаг үеийн нөхцөл байдал зэрэг дотоод, гадаад нөхцөлөөс үүдэн, өнөө цагт хэл бичгийн сургалтад технологийн дэвшлийг ашиглах, сургалтын арга зүйгээ хувирган өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарч байна. Энэ удаад арга зүйн хувьд санаа сэдэл өгөх зорилгоор Б.Ренчиний “Монгол хэл” шүлгийг ерөнхийгөөс тусгай, бүхлээс хэсэг, бодитоос хийсвэр гэсэн зарчмаар их нэгжээс бага нэгж рүү задлан, улмаар багаас их нэгж рүү томсгон, Үндэсний бичгийн агуулгыг таниулж болох юм гэсэн санааны үүднээс тус өгүүллийг бичлээ.

Жич, Онхи шинэ зүйл биш бөгөөд мэргэдийн үзэл-номд дулдуйдснаа тодотгон өгүүлье.

## Судалгааны үр дүн

### Нэг. Цагаан толгойн бүрэлдэхүүн

Тус шүлэгт Ла, Ша-аас бусад бүх үсэг эхэн, дунд, адагт орох хувирлаараа байдаг.

ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	=	ᠮ	ᠮ
ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ
ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	=
ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ
ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ	ᠮ
=	ᠮ	ᠮ	=	ᠮ	ᠮ	=	=	=	=	ᠮ	

**Хоёр. Дэвсгэрлэх ба үл дэвсгэрлэх**

	Н	М	Л	НГ	Й	Б	Г	Р	С	Д
дэвсгэр	ᠨᠠᠨᠢᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ
	Х		Т	Ч, Ц	Ж, З	Ш				
Үл дэвсгэр	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠮᠤ

**Гурав. ОЦМХ-д дуудлага бичлэг тохирох үгс**

Бямба	Ринчин	монгол	чимэг	сайхан	чин	өв	гайхан	түмэн	би
ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ
цаг	зориг	минь	хувьтай	далай	нар	хөндий	хөгжим	үе	билиг
ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ
сан	чинь	магнай	тэнийнэм	даван	түвшин	сэцэн	оюутан	хутаг	хувь
ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ	ᠮᠤᠮᠤᠮᠤ





**8. Дүрс ялган бичих үгс**

ᠤᠯᠤᠰ	ᠭᠣᠪᠡᠵᠢ	ᠰᠢᠬᠢ	ᠴᠣᠯ	ᠤᠨᠢᠨ	ᠪᠢᠯᠢᠭ	ᠪᠡᠯᠭᠡ	ᠪᠡᠯᠭ	ᠠᠯᠰ	ᠬᠡᠲ
ул үндэс, чимээ	гоёж янзлах	~хийх	цол хэргэм	үнэн сэтгэл	билиг оюун	бэлгэ дэмбэрэл	бэлэг дурсгал	алс ирээдүй	хэт хутга
ᠪᠣᠳᠤ	ᠮᠣᠳᠤ	ᠥᠨᠦ	ᠮᠥᠩᠭᠡ	ᠶᠦᠷᠢᠶ᠋ᠠ	ᠬᠡᠬᠡ	ᠣᠭᠦᠬᠡ	ᠭᠣᠯᠢᠨ	ᠬᠤᠯᠭᠠᠷ	ᠬᠤᠪᠢ
бод-, буд-	мод бут	өнө мөнх	мөнгө төгрөг	үг яриа	үхэх төрөх	өгөх авах	гоёлын чулуу	хулгар чих	хувь заяа
ᠭᠠᠨᠰ	ᠪᠣᠳᠤᠵᠢ	ᠴᠠᠯ	ᠮᠠᠨᠳᠠᠯ	ᠴᠠᠮᠴ	ᠬᠠᠭᠵᠢ	ᠬᠤᠲᠠᠭ	ᠠᠴ	ᠰᠠᠯᠠᠠ	ᠮᠣᠳ
гаанс сэтгэ-	бодож сэтгэ-	цал буурал	мандал буурал	цамц нэх-	хааж нээ-	хутаг өлзий	худаг ус	ач зээ ач тус	салаа мод

**Дүгнэлт**

1. Энэ мэт нэгэн эхэд тулгуурлаж, Үндэсний бичгийн агуулгыг таниулан, заах боломжтой байна.
2. Ингэхдээ бага нэгжийг томсгох, ухагдахууныг нэмэгдүүлэх зарчимд тулгуурлан, харьцуулан жиших, нэгтгэн дүгнэх, багцлах, асуудал шийдвэрлэх, тайлбартай дасгал, эрэмбэлэх гэх мэт сургалтын идэвхтэй аргуудыг ашиглаж, сургалтаа зохион байгуулах нь үр дүнтэй.
3. Бидэнд өвлөгдөн ирсэн цагаан толгой, хэл зүйн бичгүүдээс харахад ихэвчлэн үеийн аргыг голчилж, бусад аргыг дагалдуулсан байна. Энэ нь нэгэнт хэвшин тогтсон бөгөөд Үндэсний бичгийн хэлний авианы зүй тогтол, үг бүтэх ёсонд үндэслэжээ.
4. Цахим зуун буюу дижитал эринд шилжрэн буй өнөө үед Үндэсний бичгийн сургалтыг нээлттэй болон төлбөрт программ ашиглах, аппликэйшн, цахим контент бүтээх зэрэг технологид суурилсан арга зүйгээр зохион байгуулах нь цаг үеийн шаардлага болоод байна

**Ном зүй**

Ринчен, Б. (2012), Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. 5-р боть, Монгол бичгийн хэлний зүй, Тэргүүн дэвтэр. Уб.  
 Баттогтох, Д. (1995). Монгол бичгийн заах арга зүйн уламжлал шинэчлэл. Уб.  
 Лхаахүү, Г. (1996). Монгол бичиг заах арга зүй. Уб.  
 Гандэлгэр, С. (2021). Хүмүүн бичгээ дээдлэн сурах судар оршвой. Уб. Удам соёл.  
<https://mongolmedleg.org/genre/>

## ON THE MATTER OF NATIONAL SCRIPT TEACHING METHODOLOGY

<sup>a</sup>Gandelger S

<sup>a</sup>Teachers School, MNUE

Corresponding author: gandelger.s@msue.edu.mn 

### Abstract

The National Script is a writing system with minimal controversy for public adherence due to its established grammar suited to its agglutinative language characteristics, standardized orthography, and specific teaching traditions. According to scholars, the history of language and writing instruction can be divided into 4 periods:

*Pre-1921 period with home and palace education, 1921-1940 period with both home and classroom education, 1941-1990 period with classroom education, and 1990 to present with classroom (online) education.* For instance, in the early periods when National Script education was specialized, language instruction focused primarily on literacy through teaching the alphabet and word recognition. This approach served its purpose for that time period. However, as modern education undergoes methodological and technological innovations, there is a need to adapt National Script teaching to align with the current era.

Although traditional teaching methods are being combined with modern approaches in education and research, there is an inevitable need to utilize technological advances and transform teaching methodologies in language education today due to internal and external factors such as foreign language influence and contemporary conditions.

This time, I have prepared this presentation based on the idea that we can teach National Script content by breaking down B. Renchin's poem "Mongolian Language" from general to specific, whole to part, and concrete to abstract principles - moving from larger units to smaller units and then building back up from smaller to larger units, with the aim of providing methodological inspiration.

### Keywords

Training, research, program, tradition, innovation